



2015 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар: 1....

Улаанбаатар хот


“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОММИССЫН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон
хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай*

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон “ГУТАЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж байгаа Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Тооллогын комисст ирүүлсэн “ҮЦТТТХТ” ХХК-ийн 2015 оны 03-р сарын 16-ны өдрөөр тасалбар болгон гаргасан “ГУТАЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа болон Үнэт цаас эзэмшигчийн тодорхойлолтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 1,471,596 ширхэг хувьцаа эзэмшдэг 11 хувьцаа эзэмшигч биеэр оролцсон ба саналын хуудсаар хувьцаа эзэмшигч оролцоогүй тул нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа болох 1,618,684 ширхэг энгийн хувьцааны 90.91 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 90.91 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Н. БАТЖИН

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

Т. ЯНЖИНДУЛАМ



2015 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар: .2

Улаанбаатар хот

“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОММИССЫН ТОГТООЛ

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дах заалт, 72 дугаар зүйл санал хураах хуудсыг тоолсон дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод болон Хурлын даргад мэдүүлсүгэй:

1. 1. “Гутал” ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;

Зөвшөөрсөн 755,591 ширхэг санал буюу 51.35 хувь, татгалзсан 0 ширхэг санал буюу 0.00 хувь, түдгэлзсэн 716,005 ширхэг санал буюу 48.65 хувь

1. 2. Компанийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудиторын дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Зөвшөөрсөн 755,591 ширхэг санал буюу 51.35 хувь, татгалзсан 539,180 ширхэг санал буюу 36.64 хувь, түдгэлзсэн 176,825 ширхэг санал буюу 12.02 хувь

1. 3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгож томилох, тэдгээрийн цалин урамшууллын зардал болон төсвийг хэлэлцэн батлах;

Зөвшөөрсөн 1,471,596 ширхэг санал буюу 100.00 хувь, татгалзсан 0 ширхэг санал буюу 0.00 хувь, түдгэлзсэн 0 ширхэг санал буюу 0.00 хувь

1. 4. 2014 оны ногдол ашгийг нэгж хувьцаанд 926 /Есөн зуун хорин зургаан/ төгрөгөөр батлах;

Зөвшөөрсөн 716,321 ширхэг санал буюу 48.68 хувь, татгалзсан 755,275 ширхэг санал буюу 51.32 хувь, түдгэлзсэн 0 ширхэг санал буюу 0.00 хувь



ASIA PACIFIC SECURITIES

BROKER DEALER AND UNDERWRITING COMPANY

1. 5. Компанийн үндсэн хөрөнгийн өнөөгийн байдалтай танилцаж батлах;

Зөвшөөрсөн 755,591 ширхэг санал буюу 51.35 хувь, 716,005 ширхэг санал буюу 48.65 хувь, түдгэлзсэн 0 ширхэг санал буюу 0.00 хувь

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Н. БАТЖИН

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

Т. ЯНЖИНДУЛАМ





2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар: 13.

Улаанбаатар хот

“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОММИССЫН ТОГТООЛ

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 заалт, 72.1.3 болон 75.4 дэх хэсэг, санал хураах хуудсаар кумулятив аргаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэлцэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр кумулятив аргаар өгсөн саналын тоо нь дараах байдалтай байгааг хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлсүгэй.

Нэг.Ердийн гишүүд

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр Дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн Саналын эрхийн тоо
1. Цэрэндорж Төмөр	1,510,921 (17.11%)
2. Чимэддорж Долгормаа	1,510,855 (17.11%)
3. Төмөр Дарима	1,510,855 (17.11%)
4. Батжаргал Батбаяр	1,432,316 (16.22%)
5. Батбаяр Батхишиг	1,432,315 (16.22%)
6. Батбаяр Баттөр	1,432,314 (16.22%)
7. Минжин Бат-Оргил	0 (0.00%)



ASIA PACIFIC SECURITIES

BROKER DEALER AND UNDERWRITING COMPANY

Тус тус санал авсанаар дараах нэр бүхий гишүүд сонгогдов. Үүнд:

ТУЗ-ийн ердийн гишүүдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн Саналын эрхийн тоо
1. Цэрэндорж Төмөр	1,510,921 (17.11%)
2. Чимэддорж Долгормаа	1,510,855 (17.11%)
3. Төмөр Дарима	1,510,855 (17.11%)
4. Батжаргал Батбаяр	1,432,316 (16.22%)
5. Батбаяр Батхишиг	1,432,315 (16.22%)
6. Батбаяр Баттөр	1,432,314 (16.22%)

Хоёр.Хараат бус гишүүд

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн Саналын эрхийн тоо
1. Хангай Алтай	2,148,825 (48.67%)
2. Буянбадрах Баянмөнх	105 (0.002%)
3. Оргой Буяннэмэх	1,132,911 (25.66%)
4. Балхаажав Бүүвэй	1,132,947 (25.66%)
5. Ширмэнхуяг Ууганжаргал	0 (0.00%)

Тус тус санал авсанаар дараах нэр бүхий гишүүд сонгогдов. Үүнд:

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн Саналын эрхийн тоо
1. Хангай Алтай	2,148,825 (48.67%)
2. Оргой Буяннэмэх	1,132,911 (25.66%)
3. Балхаажав Бүүвэй	1,132,947 (25.66%)

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Н. БАТЖИН

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

Т. ЯНЖИНДУЛАМ

“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар: 001

Улаанбаатар хот

*Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн болон аудитын тайлангийн дүгнэлт,
үндсэн хөрөнгийн өнөөгийн байдлыг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.9 болон 62.1.15 дэх хэсэг, 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэж хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 51,35%-ийн саналаар баталсныг дурьдсугай.
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудиторын дүгнэлтийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 51,35%-ийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

3. “Гутал” ХК-ийн үндсэн хөрөнгийн өнөөгийн байдлыг 51,35%-ийн саналаар *зөвшөөрч баталсан* гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б. БАТБАЯР

“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар: *002*

Улаанбаатар хот

Компанийн ногдол ашгийн хэмжээг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 болон 62.1.13 дэх хэсэг, 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. 2014 оны үйл ажиллагааны ногдол ашгийг нэгж хувьцаанд 926 /Есөн зуун хорин зургаан/ төгрөгөөр ТУЗ баталсаныг хувьцаа эзэмшигчдийн *51.3%* хувийн саналаар *Татгалзсан мөрдүүлсний*

ХУРЛЫН ДАРГА



Б. БАТБАЯР

“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар: 003

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ын гишүүд сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 болон болон 62.1.13 дахь хэсэг болон 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тооллогын комиссын 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

I. Ц.Томор

II. Б. Батбаяр

III. Ч. Дэлориаа

IV. Б. Батхшиг

V. Т. Дарима

IV. Б. Баттөр

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

I. Х. Ангай

II. О. Булчиах

III. Б. Буувой

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4. “Гутал” ХК-ийн 2015 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хавсралт 1-ээр 100%-тай баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б. БАТБАЯР



"ГУТАЛ" ХК-ийн 2015 оны 04-р сарын 30-ны
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
Хурлын тоот тогтоолын хавсралт 1

"Гутал" ХК-ийн ТУЗ-ийн 2015 Оны Зардлын Төсөв

№	Зардал	Сарын цалин /төгрөгөөр/	Тоо	БҮГД /төгрөгөөр/
1	ТУЗ-ийн дарга	3 000 000	1	36 000 000
2	ТУЗ-ийн гишүүн	800 000	8	76 800 000
3	ТУЗ-ийн н.б.дарга	800 000	1	9 600 000
4	ТУЗ-ийн бичиг хэргийн зардалд	Жилд		2 700 000
	ДҮН			125 100 000

